

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2023.05.15	A/234	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2023.05.26	A/282	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2023.06.09	A/327	Хөрөнгө зарцуулах тухай	
4	Аймгийн Засаг дарга	2023.06.21	A/355	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/234

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08, 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хот хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа, Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Хөвсгөлд тавтай морилно уу” арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Төсвийг Засаг дарга дансны “Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах” зардлаас батлагдсан жагсаалтын дагуу гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж, төсвийн зарцуулалтын болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (М.Хуягбаатар), аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын
оны 05 дугаар сарын 15-ны
өдрийн А/234 дүгээр
захирамжын хавсралт

/төгрөгөөр/

ДД	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Зохион байгуулах байрны түрээсийн зардал /МҮЭСТО/	15,188,800
2	Арга хэмжээ зохион байгуулах газрын тохижилт, бэлтгэл ажлын зардал	88005116 30905990 40909590 20,000,000
3	Мэдээлэл сурталчилгааны зардал	20,000,000
4	Хэвлэлийн зардал	5,000,000
5	Бэлтгэл зохион байгуулалтын зардал	4,000,000
6	Аймгаас оролцогчдийн замын болон үйл ажиллагааны зардал	
	Дүн	64,188,800



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/1022

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын хүүхдийн спортын их наадамд Хөвсгөл аймгаас оролцох тамирчдын зардалд 10.000.000 (Арван сая) төгрөг, "Үндэсний Номын баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны зардалд 1.000.000 (нэг сая) төгрөг, Монгол улсын гавьяат жүжигчин Р.Лхамжааын "Дэлтэй цэнхрийн Лхамжав" тайлан тогтолтод 500.000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосугай.

2. Монголын хүүхдийн спортын их наадамд Хөвсгөл аймгаас оролцох тамирчдын зардлын 10.000.000 (Арван сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын үйл ажиллагааны болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас, "Үндэсний Номын баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны болон "Дэлтэй цэнхрийн Лхамжав" тайлан тогтолтын зардлын 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ), нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.

3. Олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зоржуулалтын дагуу зарцуулахыг Биеийн тамир спортын газрын дарга (Б.Очирбат), Нийтийн номын сангийн захирал (Э.Даваачулуун) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР



6710010337



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/327

Мөрөн сум


Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.6, 6.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нэгдүгээрт хүүхэд” Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэн шинжлэх ухаан, урлаг, спортын өөрийн сонирхсон төрөл, чиглэлд онцлох амжилт гаргасан хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх, амжилт ололтыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хүүхэд нас-амжилт бахархал” уулзалт, арга хэмжээг зохион байгуулан, дэмжлэг үзүүлж урамшуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг дарга дансны “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/355

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд ашиглагдаж байгаа хяналтын камерын кабелийн худаг, сувагчлал, агаарын баганын түрээсийн 2023 оны 06 дугаар сар хүртэлх төлбөрт 2,649,174 (Хоёр сая зургаан зуун дөчин есөн мянга нэг зуун далан дөрвөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,649,174 (Хоёр сая зургаан зуун дөчин есөн мянга нэг зуун далан дөрвөн мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд батлагдсан "Гудамжны хяналтын камерын кабелийн худаг, сувагчлал, агаарын баганын түрээс, цахилгааны төлбөрийн зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ